



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 4/54

Мандалговь

Газар эзэмшүүлэх хэмжээ
өөрчлөх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйл 21.3.2 дахь заалт, 2013 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 21 дүгээр зүйлийн ХХ.1.43 дахь хэсэг, Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол улсын 2013 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 21 дүгээр зүйлийн ХХ.1.43 дахь хэсэгт тусгагдсан "Газрын кадастрын мэдээллийн сан"-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд "Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх" ажил хэрэгжсэнтэй холбогдуулан хавсралтанд дурьдсан 2 байгууллагатай 8865 м.кв/ 0,88 га/ газрыг эзэмшүүлсүгэй.

Хоёр. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан хавсралтанд заасан аймгийн Засаг даргын захирамжийн холбогдох хэсгийг мөн газар эзэмших гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гурав. Дээрх хоёр байгууллагатай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Э.Чагнаадорж/, гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч /Р.Мөнхтогтох/, аймгийн Мэргэжлийн хян алтын газрын дарга /Ш.Төрбат/ нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

010000.42

Аймгийн Засаг даргын №02 төсөлний 02. дугаар сарын
2012 өдрийн 16 тоот захирамжийн 3 дугаар хавсралт



№	Эзэмшигчийн			Өмнөх					Газарын				
	Төрийн байгууллагын	Улсын бүргэлийн дугаар	Регистрийн дугаар	Захирамжийн		Газрын			Нэгж талбарын дугаар	Хэмжээ/ м2/	Байршил	Ашиглалтын зориулалт	Эзэмшигчийн лэх хугацаа
				Огноо дугаар	Холбогдох хэсгийн дугаар	Нэгж талбарын дугаар	Хэмжээ/ м2/						
0	1	2	3	4	7	8	9	10	11	12	13	14	
1	4 дүгээр цэцэрлэг	870001014	9033912	2012.04.23.A /253	2012.04.23A /253.	111600051	3372	4809000282	3568	Онцгой байдлын газрын зуун талд	Төрийн үйлчилгээ	30	
2	"Төв АЗАА" ТӨХК	141201002	2053705	2009.04.24.158	2009.04.241 58-3 дах	4809001220	4948	4809001220	5297	Цагдаагийн газрын баруун урд талд	Төрийн үйлчилгээ	30	
	нийт					8320			8865				